БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2025 оны 19 дүгээр тогтоолоор байгуулсан бөгөөд Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, С.Замира, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, С.Одонтуяа нарын гишүүд ажилласан.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр төсөлд тусгасан их, дунд, бага гэсэн тухайн нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн зэрэглэлийг хэрхэн тогтоох, зэрэглэл тус бүрд төрийн оролцоо ямар байх;

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг төслийн зэрэглэлийг Засгийн газраар баталж мөрдүүлж байгаа нь тогтвортой байх эсэх, их эрсдэлтэй төслүүдэд төрийн хяналт, иргэдийн оролцоог тусгасан талаар;

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд байгаль орчны нөхөн сэргээлтийг зохих стандартын дагуу хэрэгжүүлэх, хяналт тавих талаар хуулийн төсөлд тусгасан эсэх;

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг алдаатай боловсруулж баталсан тохиолдолд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлсэн эсэх;

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд дахин боловсруулах үйлдвэртэй байх, хаягдлыг бууруулах асуудлыг хуулийн төсөлд тусгасан талаар асуулт асууж хариулт авлаа.

Ажлын хэсгээс төслийг байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цар хүрээ, хүчин чадал, эрсдэлийг харгалзан гурван зэрэглэлд ангилж, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тус бүр тодорхойлох;

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг Төрийн захиргааны төв байгууллага олгох, ерөнхий шинжээч, шинжээч нь Төрийн албаны тухай хуульд заасан шаардлагыг хангасан, байгаль орчны чиглэлээр ажилласан жил, мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх шаардлагыг тусгах;

Төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланг нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулах зэрэг зарчмын зөрүүтэй 10 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржоос зарчмын зөрүүтэй 4 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй байна.

Байнгын хорооны хуралдаанаар зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулсан бөгөөд олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн, анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт Та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА **Б.БЕЙСЕН**